



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эко стар ХХК-ийн “Эко стар” зочид буудлын 17/195, Текко ХХК-ийн “Хаан” зочид буудлын 17/197, Өгөөмөр алтай ХХК-ийн “Өгөөмөр алтай” зочид буудлын 17/159, Ар улаан чулуу ХХК-ийн “Соко” дэн буудлын 17/176, Туна ХХК-ийн “Дабль Ю” дэн буудлын 17/227, Билэгт учрал ХХК-ийн “Билэгт учрал” дэн буудлын 18/187, тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

1150500239

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага тус бүрээс хураан; Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 08
сарын 31 өдрийн А/73 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5204025 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.08.31

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эко стар ХХК	5088275	Эко стар	БГД-ийн 5-р хороо ЭТӨЧ 91-4
2	Текко ХХК	2595028	Хаан	СБД-ийн 10-р хороо 7-р хороолол Их тойруу 22
3	Итгэлт түнш ХХК	2791293	Ланд	БГД-ийн 16-р хороо Амарсанаагийн гудамж 54
4	Өгөөмөр алтай ХХК	2676192	Өгөөмөр алтай	СХД-ийн 12-р хороо Өнөр хороолол 37-1

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 08
сарын 31 өдрийн А/73 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ 8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.08.31

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ар улаан чулуу ХХК	2699435	Соко	СХД-ийн 18-р хороо ҮЭ гудамж 40
2	Туна ХХК	2031078	Дабль Ю	СХД-ийн 19-р хороо ҮЭ гудамж 43-1
3	Билэгт учрал ХХК	5264103	Билэгт учрал	СХД-ийн 2-р хороо Орбит 21-368